**САНГИЙН ЯАМНЫ**
**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2016 оны 02 сарын 08 өдөр | Дугаар А/35 | Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
2016 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Авлигатай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг зохион байгуулах зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Сангийн яамны "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Эдийн засгийн бодлогын газар /Г.Батхүрэл/, Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/, Санхүүгийн бодлогын газар /Б.Нямаа/, Төсвийн хөрөнгө оруулалтын газар /А.Мөнхбаясгалан/, Хөгжлийн санхүүжилт өрийн удирдлагын газар /Б.Гантулга/, Төрийн захиргааны удирдлагын газар /Ш.Жандос/, Төрийн сангийн газар /С.Наранцогт/, Төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газар /Б.Шинэбаатар/, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус даалгасугай.

Гурав. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг яамны 2016 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Ш.Жандос/-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.ГАНЦОГТ

000155

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын
2016 оны A/35 дугаар тушаалын хавсралт

# САНГИЙН ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хийх ажил | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | | | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нөөц | | | | |
| | | | Хүн хүчний | Хөрөнгө санхүүгийн | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | |
| 1. | Авлигын эсрэг хууль тог-тоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээл-лийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа та-ниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | Багаар | Шаардахгүй | Байнга | Яамны вэб сайт болон, дотоод сүлжээнд байршуулсан байх | ТЗУГ |
| 2. | | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | АТГ-аас ирүүлсэн материалыг түгээсэн талаар бүртгэл хөтлөх | ТЗУГ |
| 3. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байх | Бүх газар хэлтсүүд |
| 4. | | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсан-даа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хууль, тогтоом-жийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх | Бүх газар хэлтсүүд |
| 5. | | Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй санал солилцсон баримттай байх | Бүх газар хэлтсүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуул-сан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хяналт шалгал-тын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан байх | ТСГ, ТХЭУГ |
| 7. | | Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хууд-саар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/ | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх | ТСГ, ТХЭУГ |
| 8. | | Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний үр дүнг мэдээлсэн байх | ТСГ, ТХЭУГ |
| 9. | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх | Тухайн жилийн төсвийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 1 дүгээр сарын 10-ны дотор | ТЗУГ |
| 10. | | Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 4 дүгээр сарын 1-ний дотор | ТЗУГ |
| 11. | | Сарын төсвийн гүйцэтгэлийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Дараа сарын 8-ны дотор | ТЗУГ |
| 12. | | Улирлын төсвийн гүйцэтгэлийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Дараа сарын 8-ны дотор | ТЗУГ |
| 13. | | Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 8 дугаар сарын 15-ны дотор | ТЗУГ |
| 14. | | Хагас жилийн санхүүгийн тайланг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 8 дугаар сарын 15-ны дотор | ТЗУГ |
| 15. | | Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 9 дүгээр сарын 15-ны дотор | ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | | Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 4 дүгээр сарын 25-ны дотор | ТЗУГ |
| 17. | | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 4 дүгээр сарын 25-ны дотор | ТЗУГ |
| 18. | | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 7 дугаар сарын 1-ний дотор | ТЗУГ |
| 19. | | Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбарыг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ТЗУГ |
| 20. | | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор | ТЗУГ |
| 21. | | Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Нээлттэй болгох талаах арга хэмжээ авсан байх | ТБТГ |
| 22. | | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | ТЗУГ |
| 23. | | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор | ТЗУГ |
| 24. | | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | ТЗУГ |
| 25. | | бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | батлагдсанаас хойш 7 хоногийн дотор | ХСӨУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26. | | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуу-лах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Цахим хуудсандаа байршуулах | ТЗУГ |
| 27. | | Гадаадын зээл, тус-ламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Цахим хуудсандаа байршуулах | ХСӨУГ |
| 28. | | Улсын төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүү-лэлтийн мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | хагас /7 дугаар сарын 15-ны дотор/, бүтэн жил /1 дүгээр сарын 15-ны дотор/-ийн | ТСГ |
| 29. | | Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | хагас /7 дугаар сарын 15-ны дотор/, бүтэн жил /1 дүгээр сарын 15-ны дотор/-ийн | ТСГ |
| 30. | | Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төс-вийн нэгдсэн үзүүлэлтийн мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | хагас /7 дугаар сарын 15-ны дотор/, бүтэн жил /1 дүгээр сарын 15-ны дотор/-ийн | ТСГ |
| 31. | | Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиг-лалтын мэдээ | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ХСӨУГ |
| 32. | | Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ХСӨУГ |
| 33. | | Улсын төсвийн хэм-нэлт, хэтрэлт, түүний шалт-гааны тайлбар | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ТСГ |
| 34. | | Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Сар бүрийн 15-ны дотор | ТСГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35. | | Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүү-гийн нэгтгэсэн тайлан / | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Дараа жилийн 8 дугаар сарын 25-ны дотор/ | ТСГ |
| 36. | | Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гар-гасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ХСӨУГ |
| 37. | | Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруул-сан нэмэлт, өөрчлөлт | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Батлагдсанаас хойш 7 хоногийн дотор | ТХОГ |
| 38. | | Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Гэрээ байгуу-агдсанаас хойш 7 хоногийн дотор/ | ТХОГ |
| 39. | | Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний бай-гууллагын нууцад хамаара-хаас бусад мэдээлэл, кон-цессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний та-лаарх мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 7 хоногийн дотор | ТХОГ |
| 40. | | Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гар-гасан Засгийн газрын үнэт цаасны мэдээлэл | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ХСӨУГ |
| 41. | | Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Улирал бүр | ЭЗБГ |
| 42. | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | Яамнаас олгож буй зөвшөөрөл */тусгай зөвшөөрөл, лиценз, эрх г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/*-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Яамнаас олгож буй болон олгосон зөвшөөрлийн жагсаалт болон холбогдох мэдээллүүдийг цахим хуудсандаа байршуулах | Холбогдох газар, хэлтсүүд |
| 43. | | Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | Холбогдох газар, хэлтсүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44. | | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | Холбогдох газар, хэлтсүүд |
| 45. | | Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | Холбогдох газар, хэлтсүүд |
| 46. | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Сул орон тооны зарыг цахим хуудсанд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах | Багаар | 200.0 мян төг | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |
| 47. | | Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх | ТЗУГ |
| 48. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | Яамны болон Сангийн сайдын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | 1 дүгээр сарын 10-ны дотор цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |
| 49. | | Тендерийн баримт би-чиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /*тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт*/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |
| 50. | | Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх | Багаар | 400.0 мян төг | Тухай бүр | Өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх | ТЗУГ |
| 51. | | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |
| 52. | | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 53. | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худал-дан авсан бараа, ажил үйл-чилгээний нэр, санхүүжил-тийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсан-даа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ТЗУГ |
| 54. | | Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Зөрчлийн талаар тухай бүр мэдээлсэн байх | ТЗУГ |
| 55. | | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах | ТЗУГ, ТХЭУГ |
| 56. | | Яамны болон Сангийн сайдын багцын худалдан авах ажиллагаа-ны төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод аудит хийж, сайдын зөвлөлийн хуралд танилцуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Дотоод аудитын дүгнэлтийг сайдын зөвлө-лийн хуралд танилцуулсан байх | ТЗУГ, ТХЭУГ |
| 57. | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, тө-рийн бус байгууллагын тө-лөөллийг оролцуулсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Оролцоог хангасан байх | ТЗУГ, Холбогдох газар, хэлтсүүд |
| 58. | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох | Газар хэлтсүүдийн ажил үүргийн ерөнхий хуваарийг баталсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Ерөнхий хуваарь батлагсан байх | ТЗУГ |
| 59. | | Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Ажлын байрны тодорхойлолтууд батлагдсан байх | ТЗУГ |
| 60. | | Ажлын байрны тодорхойлолтод авлигаас ангид байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар заалт оруулах арга хэмжээг тогтмол гүйцэтгэх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Яамны нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан байх | ТЗУГ, Холбогдох газар, хэлтсүүд |
| 61. | | Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт нээлттэй байлгах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах | ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 62. | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж, хэвлэл мэдээлэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх сэн байх | ТХЭУГ, ТЗУГ, Холбогдох газар, хэлтсүүд |
| 63. | | Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэг-жүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | |
| 64. | | Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | |
| 65. | Авлигын эсрэг хууль тогтоом-жийн хэрэгжил-тийг зохион байгуулах, АТГ-тай харилцах ЭБАТ-тай байх | ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Ажлын байрны тодорхойлолтод туссан байна | ТЗУГ |
| 66. | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Сургалтад тухай бүр хамрагдсан байна | ТЗУГ |
| 67. | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /*тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биеэр, хайрцаг байршуулах г.м*/-ийг бүрдүүлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх | ТЗУГ, Ёс зүйн хороо |
| 68. | | Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Урьдчилан сэргийлэх болон хариуцлагын арга хэмжээг авсан байх | ТЗУГ, Ёс зүйн хороо |
| 69. | | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хэрэгжилтийг мэдээлсэн байх | Ёс зүйн хороо |
| 70. | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг | ХХААБГ, ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх | хаагчдад танилцуулсан байх | | | | гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх | |
| 71. | | Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Судалгааг гаргасан байх | ТЗУГ |
| 72. | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Сайд, ТНБД-ын тушаалыг цахим хуудсандаа байршуулсан байх | ХХААБГ, ТЗУГ |
| 73. | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | ХХААБГ, ТЗУГ |
| 74. | | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Цахим хуудсанд байршуулсан байх | Холбогдох газар, хэлтсүүд |
| 75. | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | Хууль тогтоомжоор тогтоосон Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх | ТЗУГ |
| 76. | | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (бичгээр, амаар г.м хэлбэрээр) | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах утас, хайрцаг ажиллуулах, вэб хуудсанд тусгай булан нээж ажиллуулах | ТЗУГ |
| 77. | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | ТЗУГ |
| 78. | | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Иргэдийн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн | ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх | | | | талаар хэвлэл, мэдээллээр мэдээлсэн байх | |
| 79. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гаргах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалт гарсан байх | ТХЭУГ |
| 80. | | Төрийн захиргааны болон улс төрийн албан тушаалд шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг АТГ-т хүргүүлэн хянуулж, холбогдох зөвшөөрөл авсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | ХАСУМ-ыг тухай бүр хянуулсан байх | ТЗУГ |
| 81. | | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтад орсон ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлсэн байх | ТЗУГ |
| 82. | АТГ-аас гаргасан шийдвэрийг биелүүлэх | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдэл, албан бичгийн мөрөөр зохих арга хэмжээ авах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Тухай бүр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх | ТЗУГ |
| 83. | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | АЭҮА-ны тайланг хүргүүлсэн байх | ТЗУГ |
| 84. | | Шинээр томилогдсон албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангах болон албан тушаалтын ХАСХОМ бөглөх, холбогдох бусад асуудлаар сургалт зохион байгуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Сургалт зохион байгуулсан байх | ТЗУГ |
| 85. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Авлигын эсрэг санал санаачилгыг дэмжиж, нэгдсэн | ТЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүчин чармайлт | амлалт г.м/-д нэгдэн оролцох | | | | байх | |
| 86. | | Яамны удирдлагаас авлига, ашиг сонирхлоос ангид байх талаар уриалга гаргах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Уриалгыг гаргаж сайтад байршуулах, | ТЗУГ |
| 87. | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, мэдээлэл зохион байгуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Мэргэжлийн хүмүүсээр сургалт, мэдээлэл хийлгэсэн байх | ТЗУГ |
| 88. | | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаа илэрхийлж, илэрхийлэх хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулах | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | Илэрхийлэх хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулан, хадгалсан байх | ТЗУГ |
| 89. | | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр зохих арга хэмжээ авсан байх | Багаар | Шаардахгүй | Тухай бүр | | ТЗУГ |

САНГИЙН ЯАМ